



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1.

Чингис

Галзуу өвчинтэй тэмцэх, сэргийлэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

Сүүлийн жилүүдэд галзуу өвчний байгалийн голомтууд идэвхжиж мал амьтны өвчлөл буурахгүй байна. Манай улсад 2017 онд 15 аймгийн 97 сум, Улаанбаатар хотын 3 дүүргийн нийт 119 голомтоос 245 мал амьтан өвчилсөн нь 2016 онтой харьцуулахад 6.5%-аар өссөн байна. ОХУ-ын Буриад улсын Мэргэжлийн хяналтын байгууллагаас мал амьтны галзуу өвчний 35 тохиолдол бүртгэгдсэнээс 68.6%-ийг үнэгний өвчлөл эзэлж байгаа тухай мэдээлж байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2017 онд Биндэр, Батноров, Норовлин, Баян-Адарга, Галшар сумдад мал амьтны галзуу өвчний 6 тохиолдол бүртгэгдэж, галзуу өвчний эрсдэлд өртөж, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 18 сумын 138 иргэн хамрагдсанаас 84.05% нь аймаг сумын төвийн иргэд эзэлж байгаа нь төв суурин газарт нохой эзэмших журмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Галзуу өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын бэлдмэлийн нөөц гадаад нийлүүлэлтээс шалтгаалан хомс байгаа зэргийг үндэслэн харьяалсан нутаг дэвсгэртээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ДААЛГАХ нь:

**Нэг. Сумын Засаг дарга, тосгоны захирагч нарт:**

1. Харьяалсан нутаг дэвсгэртээ нохой эзэмших журмыг шинэчлэн боловсруулах, эзэнтэй нохойг бүртгэлжүүлэх, пайзжуулах, гэрийн тэжээвэр амьтдыг галзуу өвчний эсрэг дархлаажуулалтад хамруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах

2. Хүн амын дунд шинэ ба дахин сэргэж буй байгалийн голомтот зоонозын халдварт өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

3. Мал сүргийн эрүүл мэнд, галзуу өвчнөөр өвчилдөг, халдвар дамжуулдаг зэрлэг амьтдын зан авирын өөрчлөлтийг тандаж Мал эмнэлгийн алба, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бэлэн байдлыг хангуулах.

4. Шинэ ба дахин сэргэж буй байгалийн голомтот зоонозын халдварт өвчин гарсан, өвчний сэжиг илэрсэн үед сумын Онцгой комиссыг хуралдуулж мэдээлэх, Мал эмнэлэг ариун цэврийн шинжилгээний хариуг үндэслэн хязгаарлалтын дэглэм тогтоох, татан буулгах, хэрэгжүүлэх арга хэмжээний шийдвэрийг оновчтой гаргаж мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах

5. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд холбогдох байгууллагыг мэдээ мэдээллээр хангаж ажиллах

6. Төв суурин газарт эзэнгүй нохой муурыг устгах, устгасан тухай ЗӨСТ-д мэдээлэх

7. Эзэнтэй нохойд уруулж, ноцуулсан тохиолдолд нохой эзэмшигчдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх

8. Хүн урж ноцсон эзэнтэй нохойг 10 хоног уяж зан төрхөд МЭБ-аар ажиглалт хийлгэх ба өвчний шинж тэмдэг илэрвэл шаардлагатай арга хэмжээг авч, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх

9. Малыг байнгын хариулга маллагаанд байлгах, уг өвчний талаар анхааруулга, сэрэмжлүүлгийг малчид, ард иргэдэд хүргэх ажлыг эрчимжүүлэх.

10. Албан даалгаврын хэрэгжилт, зохион байгуулсан ажлын талаарх бичмэл тайланг сар бүрийн 20-ны дотор аймгийн ОБГ-т хүргүүлж ажиллах

#### **Хоёр. Хүнс хөдөө аж ахуйн газрын даргад:**

1. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөө гаргаж ажиллах

2. Мал амьтны галзуу өвчний сэжигтэй дуудлагад хүн, малын эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн багийг ажиллуулах, оношийг баталгаажуулах, зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, холбогдох байгууллагыг мэдээ мэдээллээр хангаж ажиллах

3. Халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай эм, урвалж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, шатахууны нөөцийг бүрдүүлж, машин унааны бэлэн байдлыг хангах

4. Мал амьтны галзуу өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн, лабораториор онош батлагдсан үед голомтын талаарх мэдээллийг яаралтай эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, голомтод хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцох

5. Мал амьтан өвчилсөн тохиолдолд голомтод хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, сэг зэмийг зохих заавар журмын дагуу устгах

6. Өвчний голомтод байгаа өрх, хот айлын мал болон гэрийн нохой, муурыг вакцинжуулалтад бүрэн хамруулах.

7. Албан даалгаврын хэрэгжилт, зохион байгуулсан ажлын талаарх бичмэл тайланг сар бүрийн 20-ний дотор аймгийн ОБГ-т хүргүүлж ажиллах

**Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад:**

1. Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, эрсдэлтэй тодорхой бүс нутагт хүн хүч дайчлан зэрлэг ан амьтан, хээрээр үхсэн амьтдын /үнэг, чоно, хярс/ сэг зэмийг олж цуглуулан устган, зааврын дагуу халдваргүйжүүлэх ажлыг холбогдох байгууллага, сумдын ЗДТГазартай хамтран зохион байгуулах

**Дөрөв. Эрүүл мэндийн газрын даргад:**

1. Галзуу өвчний сэжиг илэрсэн даруй Мал эмнэлгийн албатай хамтран голомтын халдвар эсэргүүцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах

2. Голомтын хүн амыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, тархвар судлалын холбогдлыг тогтоох.

3. Зэрлэг амьтдад уруулж ноцуулсан, мөн гэрийн тэжээвэр амьтдад төв мэдрэлийн системд ойр уруулж ноцуулсан тохиолдолд галзуу өвчний эсрэг вакцин эмчилгээнд хамруулах.

4. Вакцины бүрэн тунд хамрагдалт, дархлаажуулалтын бэлдмэлийн нөөц зарцуулалтад хяналт тавих

5. Галзуу өвчний эсрэг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах.

6. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний талаар сургалт, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд хүргэх.

7. Голомтот нутагт оршин суугчдаас галзуу өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадал, хандлагыг тогтоох асуумж судалгаа авах, үр дүнг тооцож урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чиглүүлэх

8. Албан даалгаврын хэрэгжилт, зохион байгуулсан ажлын талаарх бичмэл тайланг сар бүрийн 24-ний дотор аймгийн ОБГ-т хүргүүлж ажиллах

**Тав. Мэргэжлийн хяналтын газрын даргад:**

1. Засаг даргын албан даалгаврын биелэлт, хязгаарлалтын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих


2. Өвчний голомтод байгаа өрх, хот айлын мал болон гэрийн нохой, муурын вакцинжуулалтад хяналт тавих.

**Зургаа. Онцгой байдлын газрын даргад:**

1. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний талаар сургалт, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд хүргэх.

2. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, биелэлтийг сар бүрийн 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт танилцуулж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА